| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 945,600.0 | 11,773,800.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 945,600.0 | 800,000.0 |
| 210602 | Тавилга | | 4,050,000.0 |
| 210604 | Урсгал засвар | | 6,923,800.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 330,200.0 |

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-------------|---------------------|
| 210702 | Дотоод албан томилолт | | 330,200.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 38,228.0 | 7,950,000.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 7,950,000.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 30,460.0 | |
| 210807 | Газрын төлбөр | 7,768.0 | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 9,995,000.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 9,995,000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 9,995,000.0 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,498,000.0 | 40,515,708.5 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,498,000.0 | 40,515,708.5 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,498,000.0 | 30,049,000.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 274,464.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага | | 10,192,244.50 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь 1.2 сая.га улсын тусгай хамгаалалттай газар нутгийн онцлог, өвөрмөц тогтоц ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсаж өөрчлөгдөх зүй тогтлыг судлах танин мэдэх зорилгоор газар нутгийн тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалах, холбогдсон хууль тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад стандартыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

Байгууллагын эрхэм зорилгоо “Байгалийн бүс бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсаж өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам)

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоол (Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

БОУАӨЯ-ны Хяналт, үнэлгээ, аудитын газар хэрэгжүүлдэг ба 2023 он 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдсэн байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/641 дүгээр тушаалаар баталсан " Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 107,376.3 мянган төгрөг буюу 46.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | |
|-------------------------------------|------------------|------------|------------------|------------|------------------|------------|
| | дүн | эзлэх хувь | дүн | эзлэх хувь | дүн | эзлэх хувь |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 101,784.5 | 44 | 99,698.1 | 29.4 | (2,086.4) | |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | 6183.3 | 6.1 | 22,858.3 | 22.9 | 16,675.0 | |
| АВЛАГА | - | | 0.0 | | | |
| УРЬДЧИЛГАА | 0 | | 0.0 | | - | |
| БАРАА МАТЕРИАЛ | 85601.2 | 84.1 | 76,839.8 | 77.1 | (8,761.4) | |
| НӨӨЦИЙН БАРАА | 10000 | 9.8 | 0.0 | 0.0 | (10,000.0) | |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 129,410.0 | 56 | 238,872.8 | 70.6 | 109,462.8 | 101.9 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 251,402.2 | 108.7 | 400,271.8 | 118.2 | 148,869.6 | 138.6 |
| ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ | -121,992.2 | -8.7 | -161,399.0 | -18.2 | (39,406.8) | -38.6 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 231,194.5 | 100 | 338,570.9 | 100 | 107,376.4 | 100 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР | | | | | - | |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 231,194.5 | 100 | 338570.9 | 100 | 107,376.4 | 100 |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 231,194.5 | 100 | 338570.9 | 100 | 107,376.4 | 100 |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 22,858.3 мянган төгрөг байгаа нь ахмадын сангийн үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 76,839.8 мянган төгрөг болж өмнөх оноос 18,761.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Төсвийн худалдан авалтаар 85,618.7 мянган төгрөгийн бараа материал, үнэ төлбөргүйгээр 8,504.9 мянган төгрөгийн бараа материал орлогод авч. Тусгай зориулалттай болон нөөц, түлш шатах, тослох материал данснаас 18,761.4 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн нь бараа материалын данс буурахад голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 400,271.8 мянган төгрөг болж 148,869.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 11,900.0 мянга, ТӨБЗГ-ын 2024.12.30 -ний өдрийн 792 тоот тогтоолоор машин тоног төхөөрөмж дансанд 2,000.0 мянган төгрөгийн дрон, проектор. Байгал орчин, аялал жуулчлалын сайдын 2024/04/26 -ний өдрийн А/241 тоот тушаалаар машин тоног төхөөрөмж дансанд 10 нэр төрлийн 78.270,1 мянган төгрөгийн хөрөнгө, авто тээврийн хэрэгсэл дансанд БОУАӨС-ын 2024.08.16 өдрийн А/671 дугаар тушаалаар 77.250,0 мянган төгрөгийн 15 ширхэг мотоцикл, ТӨБЗГ-ын 2024.12.30 -ний өдрийн 802 тоот тогтоолоор биет бус хөрөнгө дансанд 1.267,9 мянган төгрөгийн санхүүгийн программыг үнэ төлбөргүйгээр орлогод авсан. ТӨБЗГ-ын 2024.12.30 -ний өдрийн 792, 818 тоот тогтоолоор машин тоног төхөөрөмж данснаас 8 нэр төрлийн 21,819.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 36,953.5 мянган төгрөг, тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 107,376.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 610,377.8 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 210,185.4 мянган төгрөгөөр өсөж 820,563.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, 2024 оны 06 дугаар сард хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч нарт олгох 5 жилийн тэтгэмжид 31,453.4 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэнтэй холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 852,633.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 792,681.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 792,681.3 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь цалингийн сан, ажил олгогчоос төлөх НДШ-ийн 59,947.3 мянган төгрөг зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | /мянган төгрөгөөр/ | |
|-----|---|------------|-----------|--------------------|---------|
| | | | | Зөрүү | Биелэлт |
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 781,316.0 | 721,368.6 | 59,947.4 | 92.3 |
| 2 | 81701 Байгаль хамгаалах арга хэмжээний зардал | 14,603.5 | 14,599.1 | 4.4 | 99.9 |
| 3 | 81703 Ургамал хамгааллын зардал | 5,660.2 | 5,660.2 | - | 100 |
| 4 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 51,053.4 | 51,053.4 | 0.00 | 100 |
| 4 | Нийт | 852,633.1 | 792,681.3 | 59,951.8 | 92.96 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар давсан орлого 20,909.0 мянган төгрөг /Сангийн сайдын 2024.12.09-ний өдрийн 224 дугаар тушаал/, орон нутгийн төсвөөс аймаг төвийн алба хаагч нарт орон нутгийн нэмэгдэл 10,192.2 мянган төгрөг, нөхөн

сэргээлтийн орлого 274.5 мянган төгрөг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын А/885 дугаар тушаалаар 9,140.0 мянган төгрөг нийт 40,515,7 мянган төгрөг орсныг 9.606,7 мянган төгрөгийг аймгийн төвд ажиллаж байгаа ажилчдын нэмэгдэл цалинд, 585.5 мянган төгрөгийг ажил ологчоос төлөх НДШ-д, 274.5 мянган төгрөгийг тээвэр шатахуунд, 11.773,8 мянган төгрөгийг эд хогшил, урсгал засварт, 330,2 мянган төгрөгийг албан томиллолтод, 7.950,0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид, 9.995,0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд зөөврийн компьютер 1 ширхэг 4,550.0 мянган төгрөг, таблет 1 ширхэг 2,650.0 мянган төгрөг тоног төхөөрөмж, 5 нэр төрлийн 4,700.0 мянган төгрөгийн үнэ бүхий тавилга эд хогшил нийт 11,900.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан. Оны эхэнд НИК ХХК -тай тээвэр шатахууны зардал дээр шууд гэрээ хийж нийт 19,289.0 мянган төгрөгийн гэрээ хийж, 2024 оны 11 дүгээр сард төсөвт зохицуулалт хийж тээвэр шатахууны зардалд 5,300.0 мянган төгрөгийг нэмүүлсэн байна. Тусгай зориулалттай материал дансанд зэрлэг ан амьтадад биотехникийн арга хэмжээ зохион байгуулах буюу өвс, давс тавьж өгөх 4,600.0 мянган төгрөг Шинэ ирээдүй ХХК, сургалт сурталчилгааны материалд 7,950.0 мянган төгрөг Шижир зоос индранил ХХК, байгаль хамгаалагчдын тусгай зориулалтай хувцас хэрэгсэлд 9,055.0 мянган төгрөг Буянт хөрс наран ХХК, нормын хувцас хэрэгсэлд 4,719.3 мянган төгрөг Иргэн н.Амгалан нартай шууд худалдан авах гэрээ байгуулж худалдан авах ажиллагаа зарлаагүй байна.

Тус байгууллага нь Байгаль орчны газрын байранд байдаг тул байр ашиглалттай холбоотой тогтмол зардал гардаггүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Дорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 176 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2024 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Б.Бат-Өлзий, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Гантөмөр нар зурж байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 851,633.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,516.3 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 5,535.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5.4 заасны дагуу хамаарах асуудал байхгүй бөгөөд цалин, ажил олгогчоос төлөх НДШ зардлаас 59,947.3 мянган төгрөгийн хэмнэлт гарч улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитын асуудалд алдаа зөрчил илрээгүй.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудагч мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий

орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан орлогын 902,576.2 мянган төгрөгийн 15 гүйлгээ, зарлагын 150,474.8 мянган төгрөгийн 9 гүйлгээ, өмч хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 111,863.7 мянган төгрөгийн 27 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж аудитаар 628.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 10,686.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 72 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|-----------------|----------|-----------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 2 | 628.3 | 2 | 628.3 | 100% |
| Албан шаардлага | 2 | 10,686.9 | 2 | 10,686.9 | 100% |
| Нийт дүн | 4 | 11,315.2 | 4 | 11,315.2 | 100% |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Батлагдсан орон тооны хэмнэлтээс үүсэж байгаа цалингийн хэмнэлтийг бусад зардал руу гүйлгэхгүй байх. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөрөөс ирсэн үндсэн хөрөнгийг тухай бүрд нь холбогдох байгууллагын шийдвэрийг гаргуулан орлогод авч байх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,840.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

Бараа материалын тайланд 2,840.0 мянган төгрөгийн барилга засварын материалыг аж ахуйн материал дансаар дамжуулан бүртгэсэн нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 339.0 мянган төгрөгийн 1 зөрчил² илэрснээс 339.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага өгсөн болно.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Улаанбаатар хотод Говь-Алтай аймгийн Байгаль орчны газраас зохион байгуулсан "Говийн гайхамшиг-6" арга хэмжээнд АИ-92 бензин 134 литр буюу 339.0 мянган төгрөгийн шатахууныг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд зориулалт бусаар шатахууны зардалд зарцуулсан 339.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | /мянган төгрөгөөр/ | | | |
|---|------------|---------|-----------------------------------|-----|--------------------------|---------|--------------------|--------------|-----|-----|
| | | | | | | | Үүнээс | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | Залруулаагүй | Тоо | Дүн |
| Бараа материалын тайланд 2,840.0 мянган төгрөгийн барилга засварын материалыг аж ахуйн материал дансаар дамжуулан бүртгэсэн | 1 | 2,840.0 | | | 1 | 2,840.0 | 1 | 2,840.0 | | |
| Дүн | 1 | 2,840.0 | | | 1 | 2,840.0 | 1 | 2,840.0 | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ | | | | | | | |
|--|-------------|-------|--------------------|-------|-----------------|--|---------|--|-----|-----|
| | | | Үүнээс | | | | | | | |
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Тоо | Дүн |
| Улаанбаатар хотод Говь-Алтай аймгийн Байгаль орчны газраас зохион байгуулсан "Говийн гайхамшиг-6" арга хэмжээнд 134 литр буюу 339.0 мянган төгрөгийн шатахууныг зориулалт бусаар зарцуулсан байна. | 1 | 339.0 | 1 | 339.0 | | | | | | |
| Дүн | 1 | 339.0 | 1 | 339.0 | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ | | | | | | | |
|---|-------------|-----|--------------------|--|-----------------|--|---------|---|-----|-----|
| | | | Үүнээс | | | | | | | |
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | | | |
| Байхгүй | 0 | 0 | | | | | 0 | 0 | | |
| Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | |

-----oOo-----





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 08 /А0571308/

Номгон

БНА-2025/021/НА-СТА-7Ц13

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Говь-Алтай аймгийн Байгаль орчны газраас Улаанбаатар хотод зохион байгуулсан "Говийн гайхамшиг-6" арга хэмжээнд 339,020 төгрөгийн шатахууныг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль зөрчиж олгосон 339.020 төгрөгийг буруутай албан тушаалтнаар нягтлан бодогч нараар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх.

5050022

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2025 оны 05 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Б.Бат-Өлзий, нягтлан бодогч Т.Гантөмөр нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АУДИТОР

Ц.ДОРЖ

6417143544
БЮА0067 9007423

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно